

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА- 2024\91\НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/164
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.Т

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 3 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж 95,2 хувиар хэрэгжүүлсэн байна

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ч.БАЯРСАЙХАН ТАНАА

019973408

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	404,044,488.98	181,533,794.94
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	331,311,745.74	71,361,265.56
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	331,311,745.74	71,361,265.56
9	Төгрөг	331,311,745.74	71,361,265.56
10	Төрийн сангийн харилцах	331,311,745.74	71,361,265.56
27	АВЛАГА	-	49,230,243.00
29	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	49,230,243.00
60	БАРАА МАТЕРИАЛ	72,732,743.24	60,942,286.38
61	Түүхий эд материал	39,230,358.40	37,804,053.70
62	Тусгай зориулалттай материал	593,000.00	-
63	Эм боох материал	38,637,358.40	37,804,053.70
66	Хангамжийн материал	33,502,384.84	23,138,232.68
67	Бичиг хэргийн материал	1,123,700.00	826,700.00
68	Аж ахуйн материал	5,734,540.00	153,050.00
70	Түлш шатах тослох материал	1,079,200.00	847,500.00
72	Хүнсний материал	1,165,720.00	5,726,570.00
73	Бусад хангамжийн материал	24,399,224.84	15,584,412.68
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,600,033,509.13	1,826,660,593.16
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,600,033,509.13	1,826,660,593.16
108	Биет хөрөнгө	1,592,659,509.13	1,819,286,593.16
109	Барилга, байгууламж	1,314,148,784.00	1,522,225,982.00
110	Хуримтлагдсан элэгдэл	(242,080,513.02)	(266,866,941.69)
111	Авто тээврийн хэрэгсэл	130,450,000.00	130,450,000.00
112	Хуримтлагдсан элэгдэл	(58,887,777.76)	(62,796,111.10)
113	Машин, тоног төхөөрөмж	407,227,882.39	457,635,614.29
114	Хуримтлагдсан элэгдэл	(79,516,925.41)	(97,706,605.02)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	156,178,454.27	160,097,390.06
116	Хуримтлагдсан элэгдэл	(53,498,395.34)	(45,090,735.38)
122	Бусад үндсэн хөрөнгө	138,000.00	2,838,000.00
125	Номын фонд	18,500,000.00	18,500,000.00
126	Биет бус хөрөнгө	7,374,000.00	7,374,000.00
127	Програм хангамж	435,000.00	435,000.00
128	Хасагдуулга	(435,000.00)	(435,000.00)
129	Бусад биет бус хөрөнгө	7,374,000.00	7,374,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,004,077,998.11	2,008,194,388.10
213	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,004,077,998.11	2,008,194,388.10
214	Засгийн газрын хувь оролцоо	2,004,077,998.11	2,008,194,388.10
215	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/	272,050,531.95	272,050,531.95
218	-Хувьцаат	272,050,531.95	272,050,531.95
222	Хуримтлагдсан үр дүн	1,460,845,077.43	1,464,961,467.42
223	Өмнөх үеийн үр дүн	1,460,845,077.43	1,460,845,077.43
224	Тайлант үеийн үр дүн	-	4,116,389.99
226	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	271,182,388.73	271,182,388.73
230	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН	2,004,077,998.11	2,008,194,388.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,388,147,449.06	1,361,735,958.64
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	282,964,449.06	145,429,108.78
77	Нийтлэг татварын бус орлого	282,964,449.06	145,429,108.78
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	282,964,449.06	145,429,108.78
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,245,910.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	282,964,449.06	144,183,198.78
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,105,183,000.00	1,216,306,849.86
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,000.00	-
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тус	250,000.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,064,700.00	90,087,000.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,064,700.00	90,087,000.00
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	1,038,868,300.00	1,126,219,849.86
145	Эрүүл мэндийн даатгалын сангаас	1,038,868,300.00	1,126,219,849.86
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,160,843,261.79	1,324,899,889.91
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,160,843,261.79	1,324,899,889.91
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,128,725,629.69	1,265,166,701.04
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	554,205,288.39	733,447,905.01
151	Цалин	355,030,957.18	392,415,081.44
152	Нэмэгдэл цалин	143,220,045.41	273,948,330.96
153	Унаа хоолны хөнгөлөлт	7,542,000.00	6,812,000.00
154	Урамшуулал	48,412,285.80	60,272,492.61
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,622,003.41	93,464,541.03
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,024,658.76	63,869,533.22
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,270,014.99	7,512,529.03
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,113,672.46	5,908,823.28
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,111,577.04	2,423,867.97
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	10,102,080.16	13,749,787.53
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,617,978.90	66,842,028.13
165	Гэрэл цахилгааны зардал	12,914,202.10	13,099,906.03
166	Түлш, халаалтын зардал	44,216,592.00	53,376,733.20
167	Цэвэр, бохир усны зардал	487,184.80	365,388.90
170	Хангамж, бараа материалын зардал	77,399,922.00	72,313,440.00
171	Бичиг хэргийн материал	10,418,320.00	7,342,700.00
172	Тээвэр, шатахууны зардал	49,535,102.00	44,829,900.00
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	2,555,890.00	2,526,100.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	4,413,300.00	7,754,450.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	10,477,310.00	9,860,290.00
181	Нормативт зардал	228,558,789.44	163,675,278.61
182	Эм	177,457,594.44	120,991,333.61
183	Хоол	44,640,195.00	38,713,945.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,461,000.00	3,970,000.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	37,027,729.00	34,171,624.79
186	Багаж хэрэгсэл	2,586,900.00	-
188	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,292,500.00	-

189	Урсгал засвар	30,148,329.00	34,171,624.79
190	Томилолт, зочны зардал	9,197,500.00	1,574,000.00
192	Дотоод томилолтын зардал	9,197,500.00	1,574,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	2,905,419.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,383,000.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	576,000.00
197	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	292,350.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	-	507,000.00
199	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	132,000.00
201	Газрын төлбөр	-	15,069.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	93,096,418.55	96,772,464.47
210	Бараа үйлчилгээний бусад зардал	16,357,260.00	45,934,600.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,739,158.55	50,837,864.47
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,117,632.10	59,733,188.87
228	Бусад урсгал шилжүүлэг	26,170,911.00	38,913,167.00
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	26,170,911.00	38,913,167.00
242	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,946,721.10	20,820,021.87
245	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,946,721.10	20,820,021.87
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	227,304,187.27	36,836,068.73
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	21,440,936.25	32,719,678.74
281	Үнэ төлбөргүй гарсан зардал	21,440,936.25	32,719,678.74
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(21,440,936.25)	(32,719,678.74)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	205,863,251.02	4,116,389.99

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,389,620,300.00	1,168,322,516.86
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,245,910.00
78	Нийтлэг татварын бус орлого	-	1,245,910.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	1,245,910.00
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,245,910.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,389,620,300.00	1,167,076,606.86
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	284,687,300.00	-
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	284,687,300.00	-

129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,064,700.00	90,087,000.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,064,700.00	90,087,000.00
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,038,868,300.00	1,076,989,606.86
145	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүж	1,038,868,300.00	1,076,989,606.86
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,052,760,385.60	1,428,272,997.04
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,052,760,385.60	1,428,272,997.04
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,020,642,753.50	1,368,539,808.17
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	554,205,288.39	733,447,905.01
151	Үндсэн цалин	355,030,957.18	359,052,823.88
152	Нэмэгдэл	143,220,045.41	307,324,498.19
153	Унаа хоолны хөнгөлөлт	7,542,000.00	6,812,000.00
154	Үр дүнгийн урамшуулал	48,412,285.80	60,258,582.94
157	Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,622,003.41	93,464,541.03
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,024,658.22	63,869,533.22
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,270,014.99	7,512,529.03
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,113,672.46	5,908,823.28
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,111,577.58	1,470,332.38
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	10,102,080.16	14,703,323.12
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	57,617,978.90	66,842,028.13
165	Гэрэл цахилгааны зардал	12,914,202.10	13,099,906.03
166	Түлш, халаалтын зардал	44,216,592.00	53,376,733.20
167	Цэвэр, бохир усны зардал	487,184.80	365,388.90
170	Хангамж, бараа материалын зардал	69,732,848.00	70,408,290.00
171	Бичиг хэрэг	9,363,020.00	6,487,700.00
172	Тээвэр, шатахуун	44,313,938.00	44,598,200.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,555,890.00	2,776,100.00
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	2,528,690.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,500,000.00	14,017,600.00
181	Нормативт зардал	209,000,974.80	160,104,303.00
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	163,540,369.80	111,615,308.00
183	Хоол, хүнс	38,961,105.00	39,991,395.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,499,500.00	8,497,600.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	32,315,900.00	199,685,822.00
186	Багаж техник хэрэгсэл	2,586,900.00	42,624,905.00
187	Тавилга	-	8,018,000.00
188	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	5,074,000.00	2,969,500.00
189	Урсгал засвар	24,655,000.00	146,073,417.00
190	Томилолт, зочны зардал	9,197,500.00	1,574,000.00
192	Дотоод албан томилолт	9,197,500.00	1,574,000.00

194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,000.00	2,905,419.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	1,328,000.00
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	576,000.00
197	Даатгалын үйлчилгээ	-	292,350.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	-	507,000.00
199	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	132,000.00
201	Газрын төлбөр	-	15,069.00
202	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	55,000.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	16,950,260.00	40,107,500.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	16,950,260.00	40,107,500.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,117,632.10	59,733,188.87
225	Бусад урсгал шилжүүлэг	26,170,911.00	38,913,167.00
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	26,170,911.00	38,913,167.00
239	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,946,721.10	20,820,021.87
242	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,946,721.10	20,820,021.87
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	336,859,914.40	(259,950,480.18)
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	60,685,700.00	-
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,685,700.00	-
263	Дотоод эх үүсвэрээр	60,685,700.00	-
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	60,685,700.00	-
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(60,685,700.00)	-
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	276,174,214.40	(259,950,480.18)
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	55,137,531.34	331,311,745.74
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	331,311,745.74	71,361,265.56

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	272,050,531.95	363,823,252.68	163,371,177.60	652,210,902.39
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	272,050,531.95	363,823,252.68	163,371,177.60	652,210,902.39
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алда	0.00	0	961,530,227.15	961,530,227.15
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	272,050,531.95	271,182,388.73	1,460,845,074.30	2,004,077,998.11
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	272,050,531.95	271,182,388.73	1,460,845,074.30	2,004,077,998.11
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	272,050,531.95	271,182,388.73	1,460,845,074.30	2,004,077,998.11
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алда	0	0		4,116,389.99
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	272,050,531.95	271,182,388.73	1,464,961,467.42	2,008,194,388.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	331,311,745.74	(331,311,745.74)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,606,856,600.00	1,407,452,975.17	199,403,624.83	87.59
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,606,856,600.00	1,407,452,975.17	199,403,624.83	87.59
4	Бараа, үйлчилгээний зардал	1,567,856,600.00	1,368,539,808.17	199,316,791.83	87.29
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	825,509,400.00	733,447,905.01	92,061,494.99	88.85
6	Үндсэн цалин	344,517,000.00	359,052,823.88	(14,535,823.88)	104.22
7	Нэмэгдэл	344,317,500.00	307,324,498.19	36,993,001.81	89.26
8	Унаа, болон бусад нөхөн олговор	6,526,400.00	6,812,000.00	(285,600.00)	104.38
9	Урамшуулал	130,148,500.00	60,258,582.94	69,889,917.06	46.30
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,040,700.00	93,464,541.03	16,576,158.97	84.94
12	Тэтгэврийн даатгал	74,508,100.00	63,869,533.22	10,638,566.78	85.72
13	Тэтгэмжийн даатгал	8,883,200.00	7,512,529.03	1,370,670.97	84.57
14	ҮОМШӨ ний даатгал	7,107,400.00	5,908,823.28	1,198,576.72	83.14
15	Ажилгүйдлийн даатгал	1,775,600.00	1,470,332.38	305,267.62	82.81
16	Эрүүл мэндийн даатгал	17,766,400.00	14,703,323.12	3,063,076.88	82.76
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,587,000.00	66,842,028.13	20,744,971.87	76.32
18	Гэрэл цахилгаан	15,120,000.00	13,099,906.03	2,020,093.97	86.64
19	Түлш, халаалт	71,467,000.00	53,376,733.20	18,090,266.80	74.69
20	Цэвэр, бохир ус	1,000,000.00	365,388.90	634,611.10	36.54
22	Хангамж, бараа материалын зардал	96,132,900.00	70,408,290.00	25,724,610.00	73.24
23	Бичиг хэрэг	7,525,300.00	6,487,700.00	1,037,600.00	86.21
24	Тээвэр (шатахуун)	65,482,000.00	44,598,200.00	20,883,800.00	68.11
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,250,300.00	2,776,100.00	1,474,200.00	65.32
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,625,300.00	2,528,690.00	96,610.00	96.32

28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	16,250,000.00	14,017,600.00	2,232,400.00	86.26
30	Нормативт зардал	177,635,300.00	160,104,303.00	17,530,997.00	90.13
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	113,978,600.00	111,615,308.00	2,363,292.00	97.93
32	Хоол, хүнс	50,156,400.00	39,991,395.00	10,165,005.00	79.73
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	13,500,300.00	8,497,600.00	5,002,700.00	62.94
34	Эд хогшил худалдан авах	219,144,800.00	199,685,822.00	19,458,978.00	91.12
35	Багаж, техник, хэрэгсэл	44,375,000.00	42,624,905.00	1,750,095.00	96.06
36	Тавилга	20,000,000.00	8,018,000.00	11,982,000.00	40.09
37	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,500,000.00	2,969,500.00	1,530,500.00	65.99
38	Урсгал засвар	150,269,800.00	146,073,417.00	4,196,383.00	97.21
39	Томилолт, зочны зардал	4,175,000.00	1,574,000.00	2,601,000.00	37.70
41	Дотоод албан томилолт	4,175,000.00	1,574,000.00	2,601,000.00	37.70
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	4,850,000.00	2,905,419.00	1,944,581.00	59.91
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	1,500,000.00	1,328,000.00	172,000.00	88.53
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоо	1,500,000.00	576,000.00	924,000.00	38.40
46	Даатгалын үйлчилгээ	600,000.00	292,350.00	307,650.00	48.73
47	Тээврийн хэрэгслийн татвар	650,000.00	507,000.00	143,000.00	78.00
48	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	132,000.00	68,000.00	66.00
50	Газрын төлбөр	100,000.00	15,069.00	84,931.00	15.07
51	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээ	300,000.00	55,000.00	245,000.00	18.33
53	Бараа үйлчилгээний бусад зардал	42,781,500.00	40,107,500.00	2,674,000.00	93.75
54	Бараа үйлчилгээний бусад зардал	42,781,500.00	40,107,500.00	2,674,000.00	93.75
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,000,000.00	38,913,167.00	86,833.00	99.78
70	Бусад урсгал шилжүүлэг	39,000,000.00	38,913,167.00	86,833.00	99.78
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	39,000,000.00	38,913,167.00	86,833.00	99.78
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,224,245,300.00	1,168,322,516.86	55,922,783.14	95.43
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	90,087,000.00	90,087,000.00	-	100.00
104	Орон нутгийн төсвөөс	90,087,000.00	90,087,000.00	-	100.00
106	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,134,158,300.00	1,076,989,606.86	57,168,693.14	94.96
108	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,134,158,300.00	1,076,989,606.86	57,168,693.14	94.96
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,245,910.00	(1,245,910.00)	-
112	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,245,910.00	(1,245,910.00)	-
129	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	331,311,745.74	(331,311,745.74)	-
130	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	71,361,265.56	(71,361,265.56)	-
135	АЖИЛЛАГСДЫН ТОО	27.00	27.00	-	100.00
136	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
137	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	-	100.00
138	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төв нь ард иргэдэд Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн бүх төрлийн чиглэлийн үйл ажиллагаа үзүүлдэг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оныг "Эх хүүхдийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 5 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 98,2 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус Эрүүл мэндийн төв нь батлагдсан орон 38,4 гүйцэтгэлээр 34 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Тус байгууллага 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр сумын Засаг даргын нэрэмжит шалгалтаар 94,0 хувьтай, Төв аймгийн Эрүүл мэндийн газраас хяналт үнэлгээ шинжилгээний шалгалтаар 98,0 хувьтай тус тус дүгнэсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,116.4 мянган төгрөгөөр буюу 0,2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	331,311,7	71,361,3	259,950,4
Авлага		49,230,2	49,230,2
Урьдчилгаа			
Бараа материал	72,732,7	60,942,3	(11,790.4)
Үндсэн хөрөнгө	1,600,033,5	1,826,660,6	226,627.1
Нийт хөрөнгө	2,004,078,0	2,008,194,4	4,116.4
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,044,078,0	2,008,194,4	4.116.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,004,078.0	2,008,194,4	4,116.4

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 71,361.3 мянган төгрөг болж 259,950.4 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь үйл ажиллагааны мөнгөн зарлага өссөнөөс шалтгаалсан байна.

Авлага дансанд 49,230.2 мянган төгрөг байгаа нь Нийгмийн даатгалын сангаас авах авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл 11,790.4 мянган төгрөгөөр буурсан нь эм боох материал, аж ахуйн материалын үлдэгдэл багассантай холбоотой байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр 288,584.2 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл боох материал, хүнсний материал, аж ахуйн бараа материал худалдан авсан.
- Хандиваар 36,704.7 мянган төгрөгийн эм эмийн хэрэгсэл, боох материал үнэ төлбөргүй хүлээн авсан.
- Бараа материал данснаас байгууллагын үйл ажиллагаанд 337,079.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь оны эцэст 1.826.660.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 226.627.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны дэлгэрэнгүй бүртгэлээс харахад:

- 169,986.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгөөр, 107,478.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар тус тус худалдаж авсан.

- 50,837.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан
- Акталж устгасан үндсэн хөрөнгө 2023 онд 12,361.1 мянган төгрөг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,134,158.3 мянган төгрөг, орон нутгийн 90,087.0 мянган төгрөг нийт зарлагыг 1,224,245.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,224,245.3 мянган төгрөгөөр зардлыг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,224,245.3 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,076,989.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 90,087,0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,245.9 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос тус тус бүрдүүлсэн ба нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь 1,606,856.6 мянган төгрөг байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 1,407,453.0 мянган төгрөг буюу 87,6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг нийт 199,403.6 мянган төгрөгөөр, үүнээс цалин нэмэгдэл, урамшууллын зардлыг 92,061.5 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой зардлыг 20,745.0 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 25,724.6 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 17,531.0 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 19,459.0 мянган төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	71802 Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,224,245.3	1,168,322,5	55,922,8	95,5
80302	Нэг иргэнд ноогдох нормативаар	739,423,3	653,388,9	86,034,4	88,4
81603	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	394,735,0	393,370.6	-1,364,4	99,6
83603	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	34,185,1	30,745,9	3,439,2	90,0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн данс байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71602-80101	2023-12-31	Үндсэн үйл ажиллагааны зардал	95,5	1,224,245.3	1,168,322.5
2	71802-80302	2023-12-31	1 иргэнд ноогдох нормативаар	88,4	739,423.3	653,388.9
3	71802-81605	2023-12-31	Үндсэн тусламж үйлчилгээ	99,6	394,735.0	393,370.6
5	71802-83603	2023-12-31	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	100%	34,185.1	30,745.9

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт 17,294.4 мянган төгрөгийн эм эмийн хэрэгсэл авсан байна. Аймгийн Эрүүл мэндийн газраас нээлттэй тендер зарлаад гадна талын пасадны засвар хийсэн. Тендер шалгаруулсан газруудаас эм, эмийн хэрэгсэл боох материалыг нийлүүлдэг.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК -ийн ахлах аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,045,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 20,900.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16,720.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 4 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 92,061.5 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 20,745.0 мянган төгрөгөөр
- Хангамжийн бараа материал болон бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 25,724.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус эрүүл мэндийн төв нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 155 мэдээллийг байршуулж 4 мэдээллийг хугацаа нь болоогүй байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар

зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн газрын эхний 2023 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болгосон санхүүгийн тайланд хийгдсэн. Завсрын аудитын явцад хөрөнгийн болон зардлын данстай холбоотой 3,530.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж нь хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	724,901,6	3	724,901,6	100
Нийт дүн	3	724,901,6	3	724,901,6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрээр бүртгэгдэж байна. Үүнээс үүдэн эргэлтийн эмийн сангийн орлого, зарлагын гүйлгээний хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүсэж байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 1,106.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,106.2 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1.Эд хариуцагчийн тайланг холбогдох хууль журмын дагуу хийгээгүй 1,106.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу тайланг нөхөн хийлгэн, гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5,1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Хүүхдийн хоолны орц нормыг зохих журмын дагуу бодоогүйгээс хоолны материалын зарцуулалт 523.8 мянган төгрөгөөр хэтэрсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон “Эрх ба үүрэг” мөн “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг ханган ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан” Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох” журмын 4,2,3,6” Эрх бүхий этгээдээс тогтоосон норм нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг үндэслэн орц нормыг хэтрүүлэн зарцуулсан 532.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эд хариуцагчийн тайланг зохих хууль журмын дагуу хийгээгүй.	1	1,106.2					1	1,106.2				

/мянган төгрөгөөр/

Дүн	1	1,106.2					1	1,106.2			
-----	---	---------	--	--	--	--	---	---------	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	1	0					1	0				
Хүнсний материалыг орц нормын дагуу тооцоогүйгээс хүнсний материалын хэтрэлт үүссэн.	1	523.8	1	523.8								
Дүн	1	523.8	1	523.8								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn